



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар А/105

Мандалговь

Орон тооны бус зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий аймгийн Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: -Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

-Эрүүл мэндийн газрын эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар, эрсдэл үнэлгээ, гамшиг, яаралтай тусламж хариуцсан мэргэжилтэн

-Мэргэжлийн хяналтын газрын Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч

-Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын Сэтгэл зүйч

-Нийгмийн даатгалын хэлтсийн Үйл ажиллагааны тасгийн дарга

-Боловсрол, шинжлэх ухааны газрын Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн хөдөлмөр, нийгмийн хамгааллын бодлого хариуцсан мэргэжилтэн

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн

-Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Хөдөлмөрийн зах зээл, ажлын байрны шилжилт хөдөлгөөн хариуцсан мэргэжилтэн

-Тэгш хамруулах боловсролыг дэмжих нь төслийн бүсийн зохицуулагч

-Аймгийн "Чандмань тэгш эрх" ТББ-ийн тэргүүн


-Аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны тэргүүн

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын дарга

2. Зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулж, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын асуудал болон тэдний орчин нөхцөлийг сайжруулах талаар үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллахыг орон тооны бус зөвлөл (Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 03 сарын 18-ны өдрийн А/105 дугаартай захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ

4822100351